



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#9
(18)

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

IX сар




ТАНИН МЭДЭХҮЙ
(Нүүр 1-5)



ЗОЧИН-ЭРДЭМТЭНТЭЙ ЯРИЛЦЬЯ
(Нүүр 6-8)



ҮЙЛ ЯВДАЛ, МЭДЭЭ
Нүүр (9-10)



ХИЙМЭЛ ОЮУН ГЭЖ ЮУ ВЭ?

Энэ удаагийн танин мэдэхүйн булангаар хиймэл оюуны үүсэл, хөгжил, энэ нь боловсролд хэрхэн нөлөөлж байгаа талаар танилцуулж байна.

Хиймэл оюун (англи. Artificial Intelligence, AI) нь компьютерын шинжлэх ухааны салбар юм.

Хиймэл оюун ухааны систем нь алгоритм, өгөгдөл ашиглаж үйлдэл гүйцэтгэх, шийдвэр гаргах, зүй тогтлыг олох зэрэг үйлдлүүдийг бүтээдэг. Алгоритм нь AI-ны системийн тархи бөгөөд AI-ны систем ямар үйлдэл хийхийг тодорхойлогч юм.

AI нь аливаа ашиг сонирхол, онцлог чанар, харилцаа холбооны уялдаа холбоог нэмэгдүүлж, хөгжүүлэлтийг эрчимжүүлж байгаа бөгөөд тодорхой үйлдвэрлэлийн хэрэгсэл, программ хөгжүүлэлтийн салбар болон мэргэжлийн нарийн харилцааг үүсгэх чадвар бүхий технологийн хэрэгсэл, систем гэж нэрлэгддэг байна.

Хамгийн гол хөдөлгөгч хүч нь их өгөгдөл, мэдээлэл юм. Хиймэл оюун нь бидэнд олон зүйлийг автоматжуулах боломжийг олгоно. AI нь тасралтгүй үргэлжлэх шинжид суурилан маш өргөн талбарт ашиглагддаг олон хувилбарт мэдээлэл хангамж үйлчилгээг багтаасан ухаалаг технологи.

ХИЙМЭЛ ОЮУНЫ ТӨРӨЛ



Artificial Intelligence (ANI)

Тодорхой нэг

даалгаврыг гүйцэтгэх зориулалттай Хиймэл оюун. Жишээ нь: Apple's Siri, Amazon's Alexa, Google's assistant.



Artificial Intelligence (AGI)

Машин хүнтэй адилхан оюун

ухаантай гэж үздэг Хиймэл оюуны онол. Хиймэл оюун суралцах, асуудлыг шийдэх, ирээдүйн төлөвлөгөө гаргах өөрийн ухамсартай байна гэж үздэг.



Artificial Intelligence (ASI)

Хүний тархины

чадамж болон оюун ухааныг давсан хиймэл оюун. Энэ ойлголт нь одоогийн байдлаар онолын түвшинд байгаа.

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХӨГЖИЛ

John McCarthy хамгийн анхны хиймэл оюун ухааны талаарх эрдэм шинжилгээний хурал дээр **"Artificial intelligence"** буюу хиймэл оюун ухаан нэр томъёог анх гаргаж ирсэн. Мөн оны сүүлээр Allen Newell, J.C. Shaw, болон Herbert Simon нар анхны хиймэл оюун ухааны программ болох Logic Theorist ийг бүтээсэн.

Neural network дээр суурилсан бүтээлүүд хиймэл оюун ухааны ертөнцөд өргөнөөр ашиглагдах болсон.

Baidu -ийн супер компьютер зургийг дундаж оюун ухаантай хүнээс илүү таньж, ялгаж байсан.

1950



Alan Turing "Computing Machinery and Intelligence" хэмээх судалгааны ажлаа хэвлүүлсэн. Тус бүтээлдээ "Машин сэтгэж чадах уу" гэсэн асуудлыг дэвшүүлж, компьютер хүнтэй адилхан оюун ухаантай байж чадах эсэхийг тодорхойлохоор **"Turing test"** -ийг танилцуулсан.

1956



1967



Frank Rosenblatt анхны алдаанаасаа суралцдаг neural network дээр суурилсан компьютер **Mark 1 Perceptron**-г бүтээсэн.

1980



1997



IBM-ийн **Deep blue** нэртэй хиймэл оюун ухаан шатрын дэлхийн аварга Garry Kasparov -ийг хожсон.

2015



2023



Large language model (жишээлбэл Chatgpt)-ууд эрчимтэй гарч ирснээр хиймэл оюуны хөгжилд томоохон өөрчлөлт авчирсан.

GENERATIVE MODEL – УУДЫН МАНДАЛТ



ТЕКСТ – Текст болон текст токин дээр бэлтгэгдсэн GenAI /GPT-3, GPT-4, BLOOM, LaMDA гэх мэт/

КОД – Текстээс гадна программын хэл дээр бэлтгэгдсэн загвар. /OpenAI Codex/



ЗУРАГ – Заавар нь өгөгдсөн зургууд дээр бэлтгэгдсэн GenAI /Midjourney, Adobe Firefly, Dall-E гэх мэт/

ХӨГЖИМ – Бичгийн тайлбарын дагуу бичигдсэн хөгжмийн дууны долгион дээр бэлтгэгдсэн хиймэл оюун ухаан. /MusicM, MusicGen/



ВИДЕО – Тайлбартай бичлэг дээр бэлтгэгдсэн хиймэл оюун ухаан. /Gen-2, Gen-1, Make-A-Video/

МОЛЕКУЛ – Амин хүчлийн эрэмбээс протоны 3D бүтцийг таамагладаг хиймэл оюун ухаан. /AlphaFold/



Таны асуултуудад хариулж, буруу таамаглалыг эргэцүүлэх боломжтой ChatGPT-ийн туршилтын хиймэл оюунтай харилцан холбогдож үзэхийг хүсвэл дараах QR кодоор болон логон дээр даран chat.openai.com хаяг руу нэвтрэн орж бүртгүүлээрэй.



ХИЙМЭЛ ОЮУН БОЛОВСРОЛЫН САЛБАРТ



AI эрин үе эхэлж байгаа энэ үед боловсрол нь хувь хүнийг хиймэл оюунтай үр дүнтэй ажиллаж, амьдрахад хэрхэн бэлтгэх, тогтвортой нийгмийг бий болгох үндсэн асуултыг тавьж байна. Хиймэл оюун нэвтэрснээр автоматжуулалт, хиймэл оюунаас үүдэлтэй ажилгүйдэл, шинэ мэргэжлүүдийн өсөлтөд системийн хэмжээнд хариу арга хэмжээ авах эрэлт нэмэгдэж байна.

Сүүлийн үеийн тооцоогоор дэлхийн хэмжээнд 2030 он гэхэд "ажлын байр"-ны 30%-ийг автоматчилагдаж, 375 сая ажилчин өртөнө гэжээ. Үүний зэрэгцээ хиймэл оюун болон бусад технологиуд нь хүнээс өндөр ур чадварыг шаардана гэж үзсэн байна.

Боловсролд хиймэл оюуны алгоритм, системийг ашиглах сонирхол жилээс жилд нэмэгдэж, 2010 оноос хойш Web of Science болон Google-ийн эрдэмтдийн "AI" болон "Боловсрол" сэдвээр хэвлэгдсэн өгүүллийн тоо өссөн байна.

Боловсролын систем нь эдгээр өөрчлөлтийг урьдчилан харж, нэгэн зэрэг ажиллах хүчийг бэлтгэж, хиймэл оюуны эрин үед амжилтад хүрэх, ур чадвартай шинэ үеийг бэлтгэх хэрэгтэй болж байна.

"Хиймэл оюун нь тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хурдасгах сайхан боломж байж болох юм. Гэхдээ аливаа технологийн хувьсгал нь бидний урьдчилан таамаглах ёстой тэнцвэргүй байдалд хүргэдэг."

ЮНЕСКО-ГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
ОДРИ АЗУЛЕЙ.



Боловсролын системийг хиймэл оюуны эрин үе рүү шинэчлэхийн тулд бодлого боловсруулагчид Тогтвортой хөгжлийн 4-р зорилт - хүртээмжтэй, тэгш, чанартай боловсрол олгох зорилтод хүрэхийн тулд хиймэл оюуны ашиг тус болон болзошгүй эрсдэлийг судлах шаардлагатай болно гэжээ.

2023 оны 5-р сард АНУ-ын Боловсролын яам "Хиймэл оюун ба багшлахуй, суралцахуйн ирээдүй" нэртэй тайланг нийтэлсэн. Энэхүү тайланд хиймэл оюуныг өгөгдөл дэх хэв маягийг таних, үйлдлийг автоматжуулах хурдацтай хөгжиж буй технологийн багц гэж тодорхойлсон бөгөөд эдгээр шинээр гарч ирж буй технологи нь боловсролын зорилгыг урагшлуулахын тулд юу хийж болохыг ойлгоход сурган хүмүүжүүлэгчдэд чиглүүлж, гол эрсдэлүүдийг тодорхойлсон байна.

ДАВУУ ТАЛ

1. ЗААВАРЧАХ ТУСЛАХУУД

AI-ийн хүнтэй төстэй яриа өрнүүлэх чадвар нь суралцагчдад хэцүү ойлголтуудыг тайлбарлахад тусалж, зааварчилгаа өгөх боломжтой болж байна.

AI загварууд нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад илүү боломжийг олгож байна.

2. ТУСЛАХ БАГШ НАР

Багш нарын зарим захиргааны ажлуудыг орлож байна.

Хичээлийн төлөвлөгөө боловсруулах, ажлын хуудас зохиох, асуулт хариулт боловсруулах гэх мэт. Эцэг эхэд удирдлагын туслахаар ажиллаж, гэрээсээ хол зайд сургуулийн сонголтуудыг зураглаж, өргөдөл гаргах цагийг төлөвлөх, холбоо барих мэдээллийг эмхэтгэх гэх мэт зүйлсийг хийх боломжтой.

3. АДМИНИСТРАТОРЫН ТУСЛАХУУД

Төрөл бүрийн хиймэл оюуныг ашиглан сургуулийн удирдлагууд эцэг эхчүүдэд зориулсан материал, мэдээллийн товхимол болон бусад олон нийтийн оролцооны баримт бичиг зэрэг янз бүрийн харилцааны төслийг боловсруулж болно. AI системүүд нь анги, автобусны цагийн хуваарийг зохион байгуулах хүнд хэцүү ажлуудад тусалж, загвар, хэрэгцээг тодорхойлохын тулд нарийн төвөгтэй өгөгдөлд дүн шинжилгээ хийх боломжтой.

СОРИЛТ БА ЭРСДЭЛ

1. ХУУРАН МЭХЛЭЛТ

Хиймэл оюун ухааныг гэрийн даалгаврын асуудлаа шийдвэрлэх эсвэл асуулт хариулт өгөхдөө ашиглаж болно. Хиймэл оюун ухаанаар үүсгэсэн эссэ нь дараагийн боловсролын түвшинд элсэх үйл явцад сөргөөр нөлөөлнө. Хиймэл оюун ухаан ашиглан ажлаа хийж байгаа оюутнууд өөрт хэрэгтэй агуулга, ур чадварт суралцахгүй байж магадгүй.

2. НУУЦЛАЛЫН АСУУДАЛ

Оюутнууд эсвэл багш нар хиймэл хиймэл оюуны хэрэгслүүдтэй харилцах үед тэдний яриа болон хувийн мэдээлэл хадгалагдаж, дүн шинжилгээ хийх нь тэдний хувийн нууцад эрсдэл учруулж болзошгүй юм.

Олон нийтийн хиймэл оюуны системд сурган хүмүүжүүлэгчид хувийн харилцаа холбоо, хувийн мэдээлэл, эрүүл мэндийн бүртгэл, сурлагын гүйцэтгэл, сэтгэл санааны байдал, санхүүгийн мэдээлэл гэх мэт хувийн харилцаа холбоо, хамт олон, оюутнуудынхаа тухай нууц мэдээллийг оруулах, задруулахаас зайлсхийх ёстой.

3. НИЙГМИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО БУУРАХ

AI системийг ашиглахад илүү их цаг зарцуулах нь сурагчдын сурган хүмүүжүүлэгч болон ангийнхантайгаа харьцах хугацаа багасгах эрсдэлтэй.

Хүүхдүүд найз нөхдийнхөө оронд эдгээр ярианы хиймэл оюуны системд хандаж эхэлж болно. Ингэснээр хиймэл оюун нь ганцаардал, сэтгэл зүйн гутрал зэрэгт хүргэж болзошгүй.

Суралцахуйд AI-г дараах зорилгоор ашиглаж байна. Үүнд:

1. ХАЙЛТЫН ЗОРИЛГООР АШИГЛАХ


Google, Bing зэрэг бидний мэдэх хайлтын системүүд нь AI-ын тусламжтайгаар илүү оновчтой хайлт хийх боломжийг бүрдүүлдэг бөгөөд ChatGPT технологийг ашиглан харилцан ярилцах байдлаар өөртөө шаардлагатай мэдээллийг маш хялбараар олж авах боломж бүрджээ.

2. AI-Д СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХЭРЭГСЭЛ

AI-д суурилсан сургалтын хэрэгсэл: AI-д суурилсан сургалтын хэрэгсэл болон сургалтын аливаа аппликейшнууд ашиглах. Сургалтын үйл явцын аль шатанд ямар аппликейшныг ашиглах боломжтой багш тодорхойлох, ашиглах боломжийг бүрдүүлэх нь цахим суралцахуйд чухал

3. СУРГАЛТЫН ҮР ДҮНД АНАЛИЗ ХИЙХ

AI-ын бас нэг боломж нь бүх төрлийн өгөгдөлд хялбар анализ хийх бөгөөд онлайн сургалтын системүүд болон сургалтын удирдлагын системд цугларсан аливаа сургалтын үнэлгээний мэдээлэлд AI-ийн тусламжтай анализ хийж, сургалтын хоцрогдол арилгах, суралцагчдад тохирсон дасгал, даалгаврыг санал болгох зэргээр сургалтын чанарыг сайжруулах, бүх талын суралцахуйг дэмжих боломжтой болсон.



Энэхүү баримт бичиг нь хэрэглэгчид ойлгомжтой болгох үүднээс эх сурвалж болон жишээ материалуудыг агуулсан болно. Эдгээр материалууд нь янз бүрийн сэдвээр мэргэшсэн мэргэжилтнүүдийн санал, зөвлөмж, түүнчлэн төрийн болон хувийн хэвшлийн бусад байгууллагуудын үүсгэсэн, хадгалсан мэдээллийн цахим холбоос, холбоо барих хаяг, веб сайтыг агуулсан.



Энэхүү тайланг ЮНЕСКО-гийн Ирээдүйн боловсрол, инновацийн багийн Технологи, боловсролын албаны ажилтан Фэнчун Миао Бээжин хотноо зохиогдсон хиймэл оюун ба боловсролын олон улсын форумын "Багш нарыг чадавхжуулах, заах арга барилыг өөрчлөхөд хиймэл оюунаар удирдах нь" сэдэвт хэлэлцүүлэгт үндэслэн боловсруулсан болно.



БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХИЙМЭЛ ОЮУН ХӨГЖҮҮЛЭХИЙГ БОДЛОГООР ДЭМЖИХ ХЭРЭГТЭЙ.

Дэлхий дахинаа өнөөгийн бидний оршин амьдарч буй

нийгмийг аж үйлдвэрийн эрин үеэс (Society 3.0) мэдээлийн технологийн эрин үед (Society 4.0) шилжиж байгаа бөгөөд

ирээдүйд кибер болон бодит амьдрал

хосолсон шинэ эринд

(Society 5.0) шилжинэ хэмээн судлаачид таамаглаж байна.

Мэдээллийн технологийн салбарын хурдацтай хөгжил, их өгөгдөл, хиймэл оюун нь бүх салбарт хүч түрэн орж ирж байна.

Энэ талаар Доктор. **Ц.Түвшинтөр** -тэй ярилцлаа.




Доктор. Ц. Түвшинтөр нь ХБНГУ -ын Берлины техникийн их сургуулийг дүүргэж, тус сургуулийн харъяа тархалттай хиймэл оюуны "DAI-Labor" институт, ХБНГУ -ын Карлсрүэгийн их сургуулийн хиймэл оюуны салбарт тэргүүлэх институтийн нэг AIFB/FZI институтэд 4 эрдэм шинжилгээний ажилтан, постдокоор ажиллаж компьютер ухаан, хиймэл оюуны салбарт докторын зэрэг хамгаалсан. МУИС, ШУТИС -д дэд профессор, тенхимийн эрхлэгч, Мэдээллийн технологийн үндэсний паркт ерөнхий захирал, одоо компьютерын ухаан, социал информатик, харилцаа холбооны хүрээлэнгийн захирал.

Мэргэшсэн салбар: конструктив логик, хиймэл оюун, онолын информатик.

Сайн байна уу, Бидний хүсэлтийг хүлээн авч, цаг заваа гарган ярилцаж байгаад талархал илэрхийлье. Манай улс хиймэл оюунд суурилсан ямар судалгаа хөгжүүлэлт хийж байна вэ?

Хиймэл оюун нь хүний тархи, оюун ухааны бүтэц, ажиллах зарчмыг тооцоолон бодох аргаар дуурайн ажиллах цогц ухаалаг систем бүтээхийг зорьж байна. Хиймэл оюуныг философи, математик, компьютерийн ухаан, биологийн салбараас харж тайлбарлах, цаашилвал философи, суурь онол, техник технологийг бүтээж байгаа инженерчлэлийн түвшин, бизнес талаас гээд олон талаар зааглан ярих нь зохистой бөгөөд эндээс хиймэл оюуны зөв төсөөлөл бий болно.

Жишээлбэл: Хиймэл оюуны бүтээгдэхүүн ярьж байснаа хиймэл оюун бүгдийг эзлэх нь гэвэл энэ нь философийн болон суурь онол руу орж ярих болж байна. Өөр нэг жишээ манай Монгол улс хиймэл оюуны салбарт дэлхийд өрсөлдөх бүтээгдэхүүн хийж байна уу? гэвэл бид онолын болон суурь судалгааны түвшинд биш, бэлэн болсон алгоритм, технологийг ашиглаж монгол өгөгдөлд зохицуулах алгоритм, програмчлалын ажил хийж байна гэж ойлгох нь зохистой.



Манай улсын хувьд энэ хөгжлийн хаана нь явж байна вэ?

Хүн аливаа зүйлийг ажиглаад түүнээс мэдлэг боловсруулан түүнийгээ өөр шинэ мэдлэг үүсгэхэд ашиглах замаар хүний оюун ухаан ажиллаж байна. Үүнийг орлуулах ухаалаг системийн онол, технологийг бий болгохын тулд хиймэл оюуны салбар 2 чиглэлээр ажилладаг. Нэгдүгээр нь хүний оюун ухаанаар бүтсэн мэдлэгийг хэрхэн кодчилох, түүгээр ажилладаг ухаалаг систем бүтээх үүнийг бид логик, мэдлэгийн салбар буюу классик хиймэл оюуны салбар гэж үздэг. Харин эсрэгээрээ хүн мэдрэхүйн эрхтнээрээ ажиллаж өгөгдлийг хүлээж авах, сенсрын тусламж авсан өгөгдлийг боловсруулаад түүнийг хамгийн оновчтой шахмал хэлбэрт оруулж дараагийн өгөгдөл орж ирэхэд ухаалаг хариу үйлдэл хийх. Үүнийг бид өгөгдлөөс суралцах техник буюу орчин үеийн хиймэл оюун гэж ерөнхийд нь нэрлэж болно.

Энэхүү орчин үеийн хиймэл оюуны алгоритмуудаар бид хүний нүд, чих, бусад эрхтэнгүүдээр орж ирэх өгөгдлийг авч тархи мэдээллээ хадгалж байгаа шиг дижитал шахсан загварт оруулах боломжтой болсноор хүний эрхтний өгөгдөл авах, мэдрэлийн эс түүнийг боловсруулах ажлыг нэлээн өндөр түвшинд боловсруулах боломжтой болж байгаа юм.

Тэгвэл хиймэл оюун хүний оюун ухааныг хэзээ ч гүйцэхгүй гэж үзвэл нөгөө талдаа хүний оюун ухааны үр дүнд бүтээгдсэн оюуныг агуулсан системийг бий болгох классик хиймэл оюуны салбарын үр дүн, орчин үеийн хиймэл оюуны салбарын үр дүн 2 нийлж, өгөгдлөөс хүн шиг оюун дүгнэлт гаргах ухаалаг системийн суурь онолын судалгаа эрчимтэй явагдаж байна.

Бизнесийн бүтээгдэхүүн, техник, технологийн цоо шинэ бүтээл гэнэт төрдөггүй. Олон зуун сая доллар судалгаанд зориулагдаж, суурь онолыг бүтээж түүнээс шигшигдэж шилмэл онолууд нь инженерчлэлийн түвшинд нарийсаж техник, технологи болон хөгжиж, түүнийг бизнесийн салбар хүлээн авч бүтээгдэхүүн болгодог тогтолцоотой. Энэ зарчмаар манай улс суурь судалгааны хувьд одоохондоо хол хоцорсон. Харин гараад ирсэн технологи, алгоритмуудыг залуучууд хурдан хүлээн авч, инженерчлэл хийн Монгол асуудлаа шийдсэн бүтээгдэхүүн гаргах дээр сайн эрчимтэй ажиллаж байна.

Боловсролын салбарт хиймэл оюуныг хэрхэн ашиглаж, хөгжүүлэх боломжтой гэж та үзэж байна вэ?



Боловсролын салбарт хиймэл оюун хөгжүүлэх нь чухал, үүнийг бодлогоор дэмжих хэрэгтэй. Өнөөдөр самбар дээр бичсэн багшийн дуу хоолойг бичвэр болгох, самбар дээр бичсэн гар бичмэлийг бичвэр болгох, номыг автоматаар үйлдвэрлэх, сурагч эцэг эхэд багшийн өмнөөс хариулдаг ухаалаг систем, сурагчийн хоцрогдлыг таних, үүссэн шалтгааныг илрүүлэх, гаргах арга замыг заадаг зааварчилгааг хувь сурагч дээр боловсруулах гээд салбарын ирээдүй тун сонирхолтой.

Үүний төлөө бид ажиллаж, философи, мөн чанар, суурь онолыг таньж мэдэх, инженерчлэл, технологи хөгжүүлэх, дагасан хэрэглэгчийн бизнес модель зохиох гээд цогц ажлууд өрнөж байна. Бид ЭЕШ дээр ухаалаг алгоритм, багшид заавар зөвлөгөө, сурагчид хурдан ЭЕШ бэлтгэл хийх ажил дээр 2 жил гаруй ажиллаж байна. Үүний үр дүнд Дундговь аймаг 9 аймгийг хойноо орхиж 2023 оны ЭЕШ-ийн дүнгээр 9-10 байранд орсон бөгөөд аймгийн нийт сургуулиудын амжилт дээшилсэн. Үүнд, аймгийн БШУГ, сургуулиуд, багш нар бүгд идэвхийлэн ажиллаж, цахим систем, дүн шинжилгээ, ухаалаг алгоритм чухал гэдэг ирээдүйг харсан нь том дэвшил амжилт. Цаашид хоцрогдлыг арилгах, улсын шалгалт, ЭЕШ -д манлайлахад хиймэл оюун, ухаалаг алгоритмтай сургууль илүү амжилт үзүүлнэ гэдэг нь тодорхой боллоо.

Цаг гарган ярилцсанд баярлалаа. Таны цаашдын судалгааны ажилд өндөр амжилт хүсье!

ГАМШГИЙН ҮЕИЙН БОЛОВСРОЛ” БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ ТҮҮНИЙ БҮТЭЦ АГУУЛГЫН ТАЛААР САНАЛ СОЛИЛЦОО

БСҮХ-гээс “ГАМШГИЙН ҮЕИЙН БОЛОВСРОЛ” бодлогын зөвлөмж түүний бүтэц агуулгын талаар ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Дотоод Хэргийн Их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн төлөөлөл, БЕГ-ын Суралцагчийн хөгжлийн газрын төлөөлөлтэйгээр санал солилцох уулзалт зохион байгууллаа.



Уулзалтад оролцсон байгууллагын төлөөлөл энэхүү хэлэлцүүлгийг дахин өргөн хүрээнд зохион байгуулах шаардлагатай байна гэж үзсэн. Гамшиг судлалын үндэсний хүрээлэн нь жил бүрийн 10 сард цаг уурын төлөв байдлыг урьдчилан гаргаж, орон нутагт байгалийн цаг уурын сэрэмжлүүлэг мэдээллийг хүргүүлдэг байна.

Үүнтэй уялдуулж тулгуурлан боловсролын байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх нь зүйтэй юм. Мөн ДХИС-д жил бүр зохион байгуулагддаг олон улсын хуралд оролцохыг санал болголоо.

“ОРОН НУТГИЙН БОЛОН АЛСЛАГДСАН БҮСИЙН ДОТУУР БАЙРНЫ СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ХҮҮХЭД ТӨВТЭЙ ХООЛ ТЭЖЭЭЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙГ САЙЖРУУЛАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



“Орон нутгийн болон алслагдсан бүсийн дотуур байрны сурагчдад зориулсан хүүхэд төвтэй хоол тэжээл, эрүүл мэндийн хөтөлбөр”-ийг сайжруулах хэлэлцүүлэгт БСҮХ, БШУЯ, БЕГ болон “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн төлөөлөл, ажлын хэсгийн гишүүд оролцлоо.



2 дахь удаагийн хэлэлцүүлэг БШУЯ, БСҮХ, БЕГ-ын мэргэжилтэн, арга зүйчид, ЕБС-ын 70,116, 63, 29 дүгээр сургуулиудын хоол зүйч, эрүүл мэндийн багш, дотуур байрны багш нарын төлөөлөл, Японы Хүүхдийг ивээх сангийн GPE EDUAL төсөл болон “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн зохицуулагч, ажлын хэсгийн гишүүд зэрэг 25 хүн оролцлоо.

“ОЛОН НИЙТИЙН ТАТВАРЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” СЭДВЭЭР УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Татварын Ерөнхий Газраас зохион байгуулсан татварын тухай ойлголт, ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт БСҮХ-ийн бүх ЭША-нууд идэвхтэй оролцлоо.

Энэхүү сургалт хэрэгжүүлэхээр бүх нийтийн татварын тухай мэдлэг ойлголтыг сургалтын хөтөлбөрт залгамж холбоотойгоор тусгах нь зүйтэй гэдэгт санал нэгдлээ.